

2020/2021 оны хичээлийн жилд сургуульд бүртгүүлэх тухай мэдээлэл

Засгийн Газраас COVID-19 коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дагуу Боловсрол, залуучууд ба спортын яамнаас 2020-2021 оны хичээлийн жилд сургуульд хүүхэд бүртгэх журамд өөрчлөлт гарсан. Хүүхэд сургуульд бүртгүүлэх хүүхэд сургууль дээр биечлэн оролцохгүй.

Млада Болеслав хот үүсгэн байгуулсан бага сургуулиудын хувьд сургуульд хүүхэд бүртгүүлэх ажил хууль эрх тогтоомжийн дагуу дагуу явагдах боловч зарим уламжлагдаж ирсэн арга хэлбэр өөрчлөгдсөн байгаа. Өөрөөр хэлбэл Боловсролын тухай хуулийн дагуу **2020 оны 4-р сарын 1-ний** өдрөөс эхлэн **4-р сарын 30-ны өдрүүдэд** явагдана.

- 1) **Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч** нь тухайн сургуулийн **вэб хуудасны "Online zápis"** гэсэн хэсэг рүү орж шаардлагатай мэдээллийг оруулах ба холбогдох утас, хаяг зэргийг онлайнаар бөглөнө. Энэ хүснэгт нь шууд сургуулийн системд автоматаар бүртгэгдэх юм.

Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч энэхүү хүснэгтийг бөглөсний дараа гарын үсэг зурснаар хүснэгт бөглөж дуусгана. Хууль ёсны төлөөлөгч энэхүү хүснэгтийг pdf форматаар хэвлэж гаргаад гарын үсэг зурсны дараа **хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, оршин суугаа байрны бичиг, удаан хугацаанд оршин суух зөвшөөрлын** ягаан карт зэргийн хуулбарыг бэлэн болгоод:

- a. Даваа ба лхагва гаригуудын 8:00- 11:30 цагуудад эсвэл сургууль руу утсаар ярьж цаг аваад тухайн хугацаанд өөрийн биеэр аваачиж өгөх шаардлагатай
- b. Шууангаар илгээнэ
- c. Мэдээллийн хайрцаг ашиглаж болно
- d. Цахимаар гарын үсэг зураад И-мэйл хаягаар илгээж болно.

**Хэрэв хүүхдийн хууль ёсны төлөөлөгч онлайн бөглөх боломжгүй бол тухайн сургууль дээр биечлэн очиж бүртгүүлнэ.*

- 2) Хэрэв хүүхдийн хууль ёсны төлөөлөгч **„Online zápisu“**-г онлайн бөглөх боломжгүй тохиолдолд сургууль руу утсаар ярьж цаг аваад (Даваа ба лхагва гаригуудын 8:00- 11:30 цагуудад) өөрийн биеэр

очиж Хүүхэд бага сургуульд бүртгүүлэх хүснэгтийг бөглөөд **төрсний гэрчилгээний хуулбар, оршин суугаа байрны бичиг, удаан хугацаанд оршин суух зөвшөөрлын** ягаан карт зэргийн хуулбартай хамтад бүртгэл хийж буй багшид өгнө.

2020.8.31-ний өдөр 6 нас хүрэх хүүхэд бүр зайлшгүй сургуульд бүртгүүлэх журамтай. 2020 оны 9 сараас он дуусах хүртэл хугацаанд 6 нас хүрэх хүүхдүүдийн хувьд сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагын зөвлөмжийн дагуу, 2021 оны 1-р сараас 7 сарын 1 хүртэл хугацаанд 6 нас хүрэх хүүхдүүдийг бас дээрх зөвлөгөө өгөх газрын зөвлөмжийн дагуу тус тус бүртгэж авна.

Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь өөрийн оршин суугаа газраас өөр газарт байрлах сургуульд бүртгүүлэх эрхтэй боловч сургуулиуд өөрийн оршин суугаа хаягийн дагуу бүртгүүлж байгаа хүүхдийг **давуу эрхтэй элсүүлж** авах үүрэгтэй байдаг. Гэхдээ тухайн сургуулийн албан ёсны бүртгэлд заасан тооны дагуу хүүхэд элсүүлж авдаг. Тухайн дүүргийн харъяа сургуулиудын жагсаалт Нийтээр мөрдөх № 1/2018 журамд зааж өгсөн ба Млада Болеслав хотын вэб хуудаснаас олж үзэж болно.

Хэрэв тухайн хүүхэд 6 нас хүрсэн ч биеийн болон оюуны хөгжлийн хувьд үе тэнгийн хүүхдүүдээс хоцрогдолтой байх тохиолдолд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь сургуулийн бүртгэл явагдах хугацаанд захиралд хандаж бичгээр өргөдөл гаргаж өгнө. Уг өргөдлөөс гадна Боловсролын зөвлөгөө өгөх газрын, мэргэжлийн эмчийн эсвэл клиникийн сэтгэл судлаач эмчийн тодорхойлолтыг хавсаргаж өгөх шаардлагатай.

Хүүхдийн сургуульд орох хугацааг хойшлуулсан тохиолдолд тухайн хүүхэд дараачийн хичээлийн жилд автоматаар элсэж орно гэсэн үг биш бөгөөд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийг дахиж сургуульд бүртгүүлэх ёстой. Анх сургуульд орох хугацааг хойшлуулах хүсэлт гаргасан сургуулиас өөр сургуульд бүртгүүлэх боломжтой.

Хүүхэд сургуульд бүртгэж авах эсэхийг сургуулийн захирал шийднэ. Сургуульд шинээр элсэн орж буй хүүхдүүдийн нэрсийн жагсаалтыг сургуулийн байранд хүмүүст харагдахаар газарт байрлуулах ба сургуулийн вэб хуудсанд мөн жагсаалтыг нийтэлнэ. Харин сургуульд элсэж ороогүй хүүхдийн тухай тушаалыг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчид хуулинд заасан хугацаанд багтаж хүргүүлнэ.

Сургуулийн захирлын гаргасан тушаалын эсрэг Мужийн Тамгийн газарт гомдол гаргаж болох ба уг гомдлыг сургуулийн захирлаар дамжуулж өгнө.